БАТЛАВ.

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ
ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА

Б.ЦАЦРАЛ

# НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

## /2019-2020 ОН/

2019 ОН

# АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл

1.2 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол

ХОЁРДУГААР БҮЛЭГ.НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

2.1 2013-2016 оны бодлогын зорилтын хэрэгжилт

2.2 Гадаад орчны шинжилгээ

2.3 Дотоод орчны шинжилгээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

3.1 Газрын хөгжлийн үзэл баримтлал, алсын хараа, эрхэм зорилго

3.2 Газрын удирдлага, бүтэц зохион байгуулалт

3.3 Бидний эрхэмлэх үнэт зүйлс

3.4 Газрын үйл ажиллагааны стратеги зорилтууд

3.5 Стратеги зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

3.6 Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаан бүтэц

ДӨРӨВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

4.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд

4.4 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Стратеги төлөвлөгөө боловсруулах эрх зүйн үндэслэл

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Агаарын тухай, Агаарын төлбөрийн тухай хууль, Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Агаар, орчны бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөө, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны "Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг батлах тухай" 08 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2016 оны "Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарын батлах тухай" А/635 дугаар захирамжаар баталсан Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газрын бүтцийг тус тус үндэслэн боловсруулав.

### 1.2 Стратеги төлөвлөгөөний ач холбогдол

Стратеги төлөвлөгөө нь газрын эрхэм зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нөөц бололцоо, хүчин чармайлт, цаг хугацаагаа юунд төвлөрүүлэх вэ гэдгийг тодорхойлж хамтдаа хөгжих бодлогын баримт бичиг юм. Газрын дүрмээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхэд бидний өмнө ямар асуудал тулгарч байгааг тодорхойлж, түүнийг даван туулах аргачлал, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж үр дүнд хүрэх бодлогын чиглэл болно. Стратеги төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлснээр агаарын чанарыг нарийвчлан тодорхойлж, агаарын бохирдлыг бууруулах талаар, төр, засаг, нийслэлийн удирдлагуудаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, хөтөлбөр, стандартын төсөл боловсруулж, салбарын бодлогын уялдаа холбоо хангагдан, байгууллагын дотоод зохион байгуулалт боловсронгуй болно.



## ХОЁРДУГААР БҮЛЭГ. НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

### 2.1 2013-2016 оны бодлогын зорилтын хэрэгжилт

БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТ

| № | Бодлогын зорилт | Хариуцсан ажил | Биелэлт |
|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 2 | 100% |
| 3 | Улсын Их хурлын болон Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл | 6 | 100% |
| 4 | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр | 10 | 100% |
| 5 | Нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт-2016 | 12 | 100% |
| 6 | НИТХ болон Тэргүүлэгчдийн тогтоол шийдвэрийн биелэлт | 5 | 100% |
| 7 | Нийслэлийн Засаг даргын Засгийн газрын гишүүдтэй байгуулсан Санамж бичгийн биелэлт | 10 | 100% |
| 8 | Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт | 5 | 90% |
| | **Нийт** | 50 | 98,75% |

### 2.2 Гадаад орчны шинжилгээ

Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулахад гадаад орчны хүчин зүйлсийн нөлөөлөл, шалтгааныг шинжлэх шаардлагатай байдаг.

| **ГАДААД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ** | |
|---|---|
| Орчны хүчин зүйл | Тайлбар |
| Улс төрийн хүчин зүйл | Агаарын чанарыг сайжруулах бүс, бүсэд мөрдөх журмыг жил бүр шинэчлэн батлах |
| | Сонгуулийн үр дүнгээс шалтгаалж, Агаарын бохирдлын салбарын тогтвортой байдлыг хангах |
| Эдийн засгийн хүчин зүйлс | Улсын төсвөөс нийслэлд олгох санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэх |
| | Үндэсний хөтөлбөр, Агаар орчны бохирдлыг бууруулах мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг улс, нийслэлийн төсөвт тусгах |
| Нийгмийн хүчин зүйлс | Нийслэл рүү шилжих хүн амын шилжилт хөдөлгөөнийг тодорхой хугацаанд хязгаарлах |
| | Агаарын бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх |
| | Агаарын бохирдлоос эрүүл мэндээ хамгаалах талаар иргэдэд мэдлэгийг нэмэгдүүлэх |
| Технологийн хүчин зүйлс | Мэдээллийн технологийн шинэ ололтуудыг ашиглах |
| | Нарийн мэргэжил шаардсан, өндөр технологид суурилсан үйлдвэрлэл үйлчилгээг нэвтрүүлэх |

## 2.3 Дотоод орчны шинжилгээ

| ДОТООД ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ | |
|---|---|
| **Давуу тал** | **Сул тал** |
| Мэргэжлийн боловсон хүчний залгамж чанартай | Газрын хүний нөөцийн бодлогоор боловсон хүчний мэргэшүүлэх |
| Байгууллагын дотоод уур, амьсгал, эв нэгдлийг бэхжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулдаг | Нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, мэдээлэл солилцох байдлыг сайжруулах |
| Жайка олон улсын байгууллагын төсөл хэрэгжиж байгаа. | Ажиллагсдын тоо цөөн |
| **Боломж** | **Аюул занал** |
| Хүний нөөцийн тогтвортой бодлого хэрэгжүүлэх | Зохион байгуулалтын шинэ бүтцийг төлөвшөөгүй байхад нь өөрчлөх |
| Чанарын менежментийн тогтолцоо ISO900:2015 олон улсын стандартыг байгууллагын үйлчилгээнд нэвтрүүлэх | Агентлагын чиг үүргийн давхардал гарах |
| Хувь хүний хөгжлийг дэмжих | Орон тоог нэмэгдүүлэх |

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

### 3.1 Байгууллагын үндсэн чиг үүрэг

Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар нь агаарын чанарыг тодорхойлох, хяналт, шинжилгээ хийх, агаарын чанарын төлөв байдалтай холбоотой мэдээ, мэдээллээр хангах, агаарын бохирдлыг бууруулах, багасгах талаар төр, засаг, нийслэлийн удирдлагуудаас гаргасан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, агаар хамгаалахтай холбогдсон дүрэм, журам, хөтөлбөр, стандартын төсөл боловсруулах зэрэг ажлыг хийж гүйцэтгэх чиг үүрэгтэй.

### 3.2 Алсын хараа

Цэвэр агаартай цэнгэг хот

### 3.3 Эрхэм зорилго

Нийслэл хотынхоо ард иргэдийг цэвэр агаартай, эрүүл орчинд ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлэх.

### 3.4 Газрын удирдлага, бүтэц зохион байгуулалт

Газрыг байгуулах, өөрчлөх асуудлыг Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор, бүтэц, орон тооны хязгаар, үйл ажиллагааны дүрмийг Нийслэлийн Засаг даргын захирамжаар батална. Байгууллага дахь зохион байгуулалтын нэгжүүдийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын асуудлыг нарийвчлан зохицуулсан дүрмийг Газрын дарга батална.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч нь Нийслэлийн агаарын бохирдолтой тэмцэх газрын даргыг томилж, чөлөөлнө. Газрын дарга нь газрын орлогч дарга, алба, хэлтсийн дарга, албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

**Зохион байгуулалт:**

Газрын дарга дэргэдээ байгууллагын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар түүнд зөвлөх, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Зөвлөл байгуулан ажиллуулж болно. Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Газрын дарга батална.

## НИЙСЛЭЛИЙН АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- Газрын дарга
  - Орлогч дарга
    - Захиргааны хэлтэс /6 хүн/
      - Хэлтсийн дарга
      - Хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн
      - Хяналт шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
      - Төлөвлөгөө, гүйцэтгэл, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
      - Сургалт, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн
      - Архив, бичиг хэргийн эрхлэгч
    - Бодлогын хэрэгжилтийн хэлтэс /8 хүн/
      - Хэлтсийн дарга
      - Түлшний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
      - Хэсэгчилсэн дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн
      - Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн
      - Авто тээврийн бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
      - Төлөвлөлт, гүйцэтгэл, тооцоо, судалгаа хариуцсан мэргэжилтэн
      - Агаарын бохирдлын нөлөөлөл, тархалтын загварчлал хариуцсан мэргэжилтэн
      - Дотоод орчны бохирдол хариуцсан мэргэжилтэн
    - Агаарын чанар, хяналт зохион байгуулалтын хэлтэс /8 хүн/
      - Хэлтсийн дарга
      - Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн
      - Агаар бохирдуулах эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн
      - Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн
      - Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн
      - Оператор, техникч
      - Оператор, техникч
      - Жолооч

### 3.5 Бидний эрхэмлэх үнэт зүйлс

- Мэдлэгийг эрхэмлэх: Хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд хангалттай мэдлэгтэй байж, түүнийгээ цаг үеийн эрэлт шаардлагад нийцүүлэн мэдлэг, чадвараа байнга хөгжүүлнэ.

- Чадварыг эрхэмлэх: Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд зохистой арга барил, ур чадвар, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг эзэмшиж, түүнийгээ ажлаа чадамгай, үр бүтээлтэй гүйцэтгэхэд ашиглана.

- Хууль ёсыг эрхэмлэх: Төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах болон төрийн албаны бүхий л үйл ажиллагаанд Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн сахина.
- Ёс зүйг эрхэмлэх: Төрийн албаны ёс зүйн үнэт зүйлс, зарчим, хэм хэмжээг сахин ажиллана.

- Шударга ёсыг эрхэмлэх: Газрын үйл ажиллагаа явуулах, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад аливаа хэлбэрээр ялгаварлахгүй, ямарваа хөндлөнгийн нөлөөлөлд орохгүй, ашиг сонирхлын аливаа зөрчилд автахгүйгээр зөвхөн нийтийн ашиг сонирхолд нийцүүлж, чин шударгаар ажиллана.

- Соёлтой харилцааг эрхэмлэх: Иргэдэд байнга хүндэтгэлтэй хандаж, тэдний итгэлийг олох хэмжээнд харилцааны соёлыг эзэмшин, үйл ажиллагаа, үйлчилгээгээ эелдэг, ил тод байлгаж, олон нийтийн санаа бодлыг байнга авч, тэдний эрэлт хэрэгцээнд нийцүүлж ажиллана.

- Үнэнч байдлыг эрхэмлэх: Төрийн албандаа ямагт чин сэтгэлээс өөриймсөг хандаж, албан үүргээ аль болох үр бүтээлтэй, илүү чанартай гүйцэтгэх талаар санаачилга, идэвх зүтгэл гарган, иргэдэд төрийн үйлчилгээг бүрэн дүүрэн үзүүлэх талаар боломжтой бүх нөөц бололцоог дүүрэн ашиглаж ажиллана.

- Шуурхай байдлыг эрхэмлэх: Газрын үйл ажиллагааг явуулахад бусдад элдэв чирэгдэл учруулахгүй байж, ялангуяа иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтэд нэн анхааралтай хандаж, боломжтой хамгийн бага хугацаанд шийдвэрлэн хариу өгөх хэмжээнд ажлаа зохион байгуулна.

- Хариуцлага, ил тод байдлыг эрхэмлэх: Хууль тогтоомжийн хүрээнд мэдээллийн ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан, ажилдаа эзэн болж түүнийхээ гүйцэтгэлийн үр дүнг биечлэн хариуцна.

- Бүтээлч байдлыг эрхэмлэх: Хариуцсан ажлынхаа чиглэлээр шинийг эрэлхийлэх, шинэ ололт амжилтыг ажилдаа нэвтрүүлнэ.
- Багийн ажиллагааг эрхэмлэх: Бусдыг хүлээн зөвшөөрч цаг ямагт багийн ажиллагааг эрхэмлэн ажиллана.

**Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө**

| Стратегийн зорилт | № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хариуцан зохион байгуулах | Хугацаа | Шийдвэр гаргах |
|---|---|---|---|---|---|---|
| Зорилт 1. Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаарын чанарыг сайжруулах | 1.1 | Агаарын тухай хуулийн дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, дэглэмийг мөрдүүлэх | Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож, журмын хэрэгжилтийг мөрдүүлсэн байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | Жил бүр | БОАЖЯ, НЗД |
| | 1.2 | Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байгаа 228 халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж, хэрэглэгчдийг төвлөрсөн дулаан хангамжид холбох | 228 халаалтын зуухыг буулгаж, 445 барилгыг төвлөрсөн дулаан хангамжид холбох зураг төсөв хийгдсэн байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 | ЭХЯ, НЗДТГ |
| | 1.3 | Амгалан дулааны станц орчмын дулааны шугамд холбогдох боломжтой усан халаалтын зуух бүхий объектуудын жагсаалтыг гаргаж, тэдгээрийг дулаан хангамжийн сүлжээнд холбох | Амгалан дулааны станц орчмын дулааны нэгдсэн шугамд холбогдох боломжтой усан халаалтын зуухнуудын судалгааг хийж, тэдгээрийг дулаан хангамжийн сүлжээнд холбосон байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 он | ЭХЯ, НЗДТГ |
| | 1.4 | Амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхөд цахилгаан халаагуур нийлүүлэх | 290-ээс багагүй өрхөд үнэ төлбөргүй дэвшилтэт технологи бүхий цахилгаан халаагуур нийлүүлсэн байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2019-2020 | НЗДТГ |
| Стратегийн зорилт 2 Байгальд ээлтэй, дэвшилтэт техник, | 2.1 | Нийслэлийн гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагыг | Жилд 80 мян-аас доошгүй тонн сайжруулсан түлш үйлдвэрлэдэг болсон байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 | ЭХЯ, НЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| технологи нэвтрүүлэх замаар бохирдлын эх үүсвэрийг багасгаж, түүхий нүүрсний хэрэглээг үе шаттайгаар хориглож, бохирдуулах бодисын хаягдлыг бууруулах | | стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлш үйлдвэрлэх үйл ажиллагаag дэмжин хөгжүүлэх | | | | |
| | 2.2 | Сайжруулсан түлш нөөцлөх, түгээлт, борлуулалтын цэгүүдийг бий болгох | Түгээлт, борлуулалтын цэгүүдийг байгуулсан байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2019-2020 | НЗДТГ |
| | 2.3 | Сайжруулсан түлшний экологийн шаардлагыг тодорхойлох стандарт, аргачлал боловсруулах | Сайжруулсан түлшний экологийн шаардлагыг тодорхойлох стандарт боловсруулсан байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| | 2.4 | Агаарын чанарыг сайжруулах бүсийн зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангах | Зорилтот бүлгийн айл өрхийг сайжруулсан түлшээр хангасан байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2019-2020 | НЗДТГ |
| | 2.5 | Шөнийн тарифын хөнгөлөлтт цахилгаан халаагуурыг судлах, турших | Сонгосон байршилд дулаан хуримтлуурт халаах хэрэгслийг туршин дүгнэлт гаргасан байна | Агаарын чанарын хяналтын хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| | 2.6 | Төвлөрсөн дулаан хангамжийн нэгдсэн системд холбогдоогүй алслагдсан төрийн байгууллагын дулаан хангамжийг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологи ашиглан шийдэх | 10 хорооны барилгын дулааны хэрэглээг сэргээгдэх эрчим хүч болон бусад үр ашигтай технологид шилжүүлсэн байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| | 2.7 | Нийслэлийн "Ногоон | Нийслэлийн “Ногоон | Бодлогын | 2018- | НЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | зээлийн сан" байгуулах эрхзүйн орчин бүрдүүлэх | зээлийн сан"-эрхзүмн орчинг бүрдүүлсэн байна. | хэрэгжилтийн хэлтэс | 2020 | |
| | 2.8 | Агаарын бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг олон нийтэд дэлгэн үзүүлэх "Байгаль орчинд ээлтэй техник, технологийн үзэсгэлэнгийн төв" байгуулах | Нийслэлд байгаль орчинд ээлтэй техник, технологийн 1-ээс доошгүй төв байгуулсан байна. | Бодлогын хэрэгжилтийн хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| Зорилт 3. Авто тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулах бодисын хэмжээг бууруулах цогц арга хэмжээ авах | 3.1 | Нийтийн тээвэрт Евро4-өөс дээш стандарттай том оврын автобусыг импортолж ашиглах | Нийтийн тээвэрт Евро4-өөс дээш стандарттай том оврын автобусыг импортолж, ашиглах эрхзүйн орчныг бүрдүүлсэн байна. | Агаарын чанарын хяналтын хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| | 3.2 | Нийслэлийн нийтийн тээврийн дизель автобусанд дизель түлшнээс ялгарах нарийн ширхэглэгт хорт шүүлтүүр буюу DPF, түүнийг цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулах, байнгын үйлчилгээ хийх | Нийтийн тээврийн дизель автобусанд дизель түлшнээс ялгарах нарийн ширхэглэгт хорт бодисын шүүлтүүр буюу DPF,шүүр цэвэрлэх тоног төхөөрөмжийг суурилуулж, найдвартай ажиллагааг хангасан байна. | Агаарын чанарын хяналтын хэлтэс | 2018-2020 | НЗДТГ |
| Стратегийн зорилт 4. Агаарын бохирдлыг бууруулах үйл ажиллагааны удирдлага зохицуулалт, санхүүжилтийг | 4.1 | Дүүргүүдэд агаарын бохирдлыг бууруулах ажлыг хариуцсан нэгж байгуулах, нэгжид хороог хариуцсан агаарын чанарын байцаагчийн орон тоог бий болгох | Нийслэлийн 9 дүүргийн хороо бүрт агаарын чанар хариуцсан албан хаагчын орон тооны асуудлыг шийдвэрлэсэн байна. | БХХ | 2019-2020 | НЗДТГ |
| | 4.2 | Хороодын Засаг дарга | Агаарын бохирдлыг | БХХ | 2019- | НЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| тодорхой болгож, агаар, орчны бохирдлыг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг урамшуулах тогтолцоог бий болгох | | нарын ажпын чиг үүрэгт агаарын бохирдлыг бууруулах, түүнд хяналт тавих үйл ажиллагаа тусгах | бууруулах, хяналт тавих үйл ажиллагааны хэрэгжилийг Хороодын Засаг дарга нарын ажлын үнэлгээнд оруулж тооцсон байна. | | 2020 | |
| | 4.3 | Хороодын хэсгийн ахлагч нарт агаарын бохирдлыг бууруулахад хяналт тавих орон тооны бус байцаагчийн эрх олгох | Агаарын бохирдлыг бууруулахад хяналт тавих орон тооны бус байцаагчийн эрхийг хороодын хэсгийн ахлагч нарт олгосон байна. | БХХ | 2019-2020 | БОАЖЯ |
| | 4.4 | Эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авагчдад зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэх | Худалдан авагчдад эрчим хүчний хэмнэлттэй гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж худалдан авахад зориулсан бага хүүтэй, урт хугацаатай зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлсэн байна. | БХХ | 2018-2020 | НЗДТГ, СЯ, БСБ |
| Зорилт 5. Агаарын бохирдпыг бууруулахад иргэд, олон нийтийн оролцоо, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, эрүүл амьдрах зөв дад. төлөвшүүлэх, орчны чанарын хяналт-шинжилгээний чадавхыг бэхжүүлэн судалгаа, шинжилгээний | 5.1 | “Агаарын бохирдлыг бууруулахад иргэн таны оролцоо" аян өрнүүлэх | Олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна. | Захиргаа, хуулийн хэлтэс | 2018-2019 | НЗДТГ, БОАЖЯ, ЭМЯ, ДЭМБ, НҮБХС |
| | 5.2 | Олон нийтийн радио, телевизээр агаарын бохирдол, түүний сөрөг үр дагавар, агаарын бохирдлоос хамгаалах энгийн арга, эрүүл зөв амьдралын хэвшил,гэр хс | Агаарын бохирдол, түүнийг бууруулах арга зам болон хорт нөлөөллөөс урьдчилан сэргийлэх чиглэлийн нэвтрүүлгийг тогтмол цагт нэвтрүүлэх олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдтэй гэрээ байгуулсан байна. 2-3 телевизийн суваг болон | БХХ | 2018-2020 | НЗДТГ, ЭМЯ, МТХ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| ажлыг өргөжүүлэх | | | радио өргөн нэвтрүүлгийн болон FM сувгуудаар 20-30 минутын тогтмол цагтай болсон байна. | | | |
| | 5.3 | Иргэд олон нийтэд мэдээлэх агаарын чанарын индексийг олон улсын жишигт нийцүүлэн, мөрдөх | Агаарын чанарын индексийг иргэд, олон нийтэд олон улсын жишгийн дагуу мэдээлдэг болсон байна. | Агаарын чанарын хяналтын хэлтэс | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ |
| | 5.4 | Гэр хорооллын нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт мониторинг явуулах ажлын хүрээнд дугуй, ажилласан тос зэрэг хог хаягдал шатааж байгааг хянах, зорилтот бүлгийн өрхийн судалгаар нягталж гаргах ажлыг иргэний нийгмийн байгууллагатай хамтарч хэрэгжүүлэх | Иргэний нийгмийн байгууллагатай хамтран 21 машин, идэвхтэн байцаагчийг ажиллуулж, хяналт эргүүл хийж, агаарын чанарыг сайжруулах бүсийн дэглэмийг мөрдүүлж, холбогдох судалгаа гаргаж, олон нийтэд хууль тогтоомжийн дагуу мэдээлэл хүргэсэн байна. | Агаарын чанарын хяналтын хэлтэс | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ, ТББ, НМХГ |
| | 5.5 | Агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах журам боловсруулах, хэрэгжүүлэх | Журам боловсруулж, агаарын бохирдлыг бууруулах, дулаан алдагдлыг багасгах, эрчим хүч хэмнэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг урамшуулах ажпыг үе шаттайгаар хэрэгжүүлж эхэлнэ. | БХХ | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ, ЭХЗХ |
| | 5.6 | Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх | Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх | БХХ | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ, |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | сөрөг нөлөөлөл болон эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга барилыг төлөвшүүлэх сургалт, сурталчилгаа | сөрөг нөлөөлөл болон эрсдэлээс хамгаалах, урьдчил сэргийлэхэд чиглэсэн арга барилыг төлөвшүүлэх сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулсан байна. | | | ЭМЯ,ТББ |
| | 5.7 | Агаарын бохирдлоос хүн амын эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг зохион байгуулах | Бохирдол ихтэй үед амны хаалт байнга хэрэглэж занших, сургууль, цэцэрлэг, эмнэлгүүдэд зориулалтын агаар цэвэршүүлэгч, агааржуулалтыг сайжруулах зэрэг ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна. | БХХ | 2018-2020 | НЗДТГ, ЭМЯ, ТББ |
| | 5.8 | Агаар бохирдуулах хаягдлын тооллого хийх аргачлал боловсруулах, туршин нэвтрүүлэх | Агаар бохирдуулах хаягдлын тооллого явуулах аргачлалаар тооллогын дүн мэдээ нэгтгэдэг болсон байна. | АЧХ | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ ЦУОШГ |
| | 5.9 | “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг шинэчлэх | “Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын нэгдсэн тоо бүртгэл явуулах журам”-ыг шинэчлэхэд санал боловсруулж хүргүүлсэн байна. | БХХ | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ ЦУОШГ |
| | 5.10 | Агаарын чанарын хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг хангаж, хүний нөөцийг чадавхжуулах | Нийслэлийн агаар, орчны чанарын хяналтын чиглэлд ажиллаж байгаа ажилтнуудыг чадавхжуулж, хяналт шинжилгээний тасралтгүй ажиллагааг : хангасан байна. | АЧХ | 2018-2020 | НЗДТГ, БОАЖЯ ЦУОШГ, ОУБ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 5.11 | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлын талаар хийгдсэн шинэлэг судалгаа, төслийн үр дүнг танилцуулах эрдэм шинжилгээний хулрыг тогтмол зохион байгуулах | Нийслэлийн хэмжээнд агаарын бохирдлыг бууруулах талаар эрдэм шинжилгээ, төслийн үр дүн болон шинэ техник технологи танилцуулах хурлыг жилд 1-2 удаа тогтмол зохион байгуулах боломжийг бүрүүлсэн байна. | | 2018-2020 | БОАЖЯ, ЦУОШГ, Их дээд сургууль |

# ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

## 4.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээний зарчим

4.1.1 Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг тогтмол хугацаанд үе шаттайгаар үнэлгээ өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг газрын даргын тушаалаар байгуулан ажиллана.

4.1.2 Газрын стратеги төлөвлөгөөг жил бүрийн байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээнд тусгуулах, явцын хяналтыг тогтмол хийх үүргийг Захиргаа, санхүүгийн хэлтэс хариуцан ажиллана.

4.1.3 Газрын стратеги төлөвлөгөөнд явцын хяналт хийж, бүтэн жилээр биелэлтийг дүгнэх нь байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлж, удирдлагын үйл явцын үр нөлөөг үнэлж, сайжруулахад оршино.

4.1.4 Урьдчилсан болон нэгтгэн дүгнэх үнэлгээ нь хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явц, үр дүн, үр нөлөөг тогтооход чиглэнэ.

4.1.5 Стратеги төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг газрын даргын тушаалаар байгуулагдсан хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

## 4.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

4.2.1 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хүрээ, хугацааг удирдамжаар тодорхойлно.

4.2.2 Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын удирдамжийг газрын дарга батална.

4.2.3 Тайланд хяналт-шинжилгээ хийхдээ хагас бүтэн жилээр гаргасан тайлан, мэдээтэй танилцаж баримт бичгийг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, санал асуулга явуулах, ажлын бодит гүйцэтгэлийг газар дээр нь шалгах зэрэг дүн шинжилгээний түгээмэл аргуудыг хэрэглэнэ.

4.2.4 Бодлогын зорилтын хэрэгжилтийн төвшинг тодорхойлохдоо тавьсан зорилтын гүйцэтгэл тогтоох шалгуур үзүүлэлтийн үр дүнг (Гүйцэтгэл) хүрэх түвшин буюу тавьсан зорилтод (Зорилт) харьцуулж хувиар илэрхийлнэ. (Г/Зх100).

4.2.5 Тоогоор илэрхийлж үнэлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.2.5.1 тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол 100 хувь

4.2.5.2 тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч эхэлж байгаа бол 90.0 хувь (80.0-100.0 хүртэл хувь)

4.2.5.3 тавьсан зорилтод хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгууллагад өргөн барьсан буюу гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн байдлыг харгалзан 70.0 хувь (60.0-80.0 хүртэл хувь)

4.2.5.4 тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 50.0 хувь (40.0-60.0 хүртэл хувь)

4.2.5.5 тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан 30.0 хувь (20.0-40.0 хүртэл хувь)

4.2.5.6 тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо, судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбогдсон арга хэмжээг авч эхэлж байгаа бол ажлын түвшинг харгалзан 10.0 хувь (0-20.0 хүртэл хувь)

4.2.5.7 тухайн зорилтыг хэрэгжүүлэх талаар ямар нэгэн ажил зохион байгуулаагүй бол биелэлтийн хувийг “0” гэж үзнэ.

### 4.3 Хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлтүүд

4.3.1 Газрын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор улс, нийслэлийн төсвийг батлах, төсвийн тодотгол хийхээс өмнө үйл ажиллагааны чиглэл тус бүрээр төлөвлөгөө боловсруулан, шаардлагатай өртгийг нь тооцож, үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана.

4.3.2 Бодлогын зорилтын суурь болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн,

үр нөлөөг тоон үзүүлэлтээр тогтооно. Тоон үзүүлэлт тогтоох боломжгүй бол чанарын шалгуур үзүүлэлтийг аль болох тодорхой тогтооно.

4.3.3 Тухайн үйл ажиллагаа болон бодлого хэрэгжиж эхлэх жилийн улсын статистик мэдээллээр гаргасан үзүүлэлт, төрийн байгууллагаас албан ёсоор гаргаж нийтэд мэдээлсэн тоон мэдээ зэргийг суурь үзүүлэлт болгон авна.

4.3.4 Шалгуур үзүүлэлт нь дараах шаардлагыг хангасан байна:

4.3.4.1 Хамааралтай буюу ач холбогдолтой байх

4.3.4.2 Урт хугацаанд хэрэглэгдэх, тогтмол байх

4.3.4.2 Хэрэглэхэд хялбар, боломжтой байх

4.3.4.3 Аль болох богино хугацаанд өөрчлөлтийг илэрхийлэхээр байх

## 4.4 Хяналт-шинжилгээ үнэлгээний үр дүнг хэрэгжүүлэх

4.4.1 Газрын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнтэй холбогдуулан “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө”-г баталж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4.4.1 Байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах

4.4.4.2 Газрын стратеги зорилтоос хариуцсан чиглэлийн хүрээнд албан хаагчид өөрийн үр дүнгийн гэрээнд тусгаж хэрэгжүүлэх

4.4.4.3 Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн шаардлагатай тохиолдолд стратегийг хэрэгжүүлэх арга хэлбэр, зохион байгуулах үйл ажиллагааг өөрчлөх асуудлыг газрын Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн тодотгох.